

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	22
7. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ХАК	Хувийн аудитын компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.25 № 94
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Л.УЧРАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгддэг "Жаргалант ус дулаан түгээх станц" ОНӨХК нь 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр ирүүлсэн боловч санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарласан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 01 дүгээр тогтоолоор Жаргалант сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 21,835,386.6 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсөв 1,643,924.7 мянган төгрөг, төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 8,252,906.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 10,358,244.9

мянган төгрөг, урьд оны шилжих үлдэгдэл 1,399,418.6 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогоор 7,100.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Жаргалант сумын төсөвт төвлөрөх 2024 оны татварын орлогыг 1,543,924.7 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,482,353.0 мянган төгрөг төвлөрч, 61,571.7 мянган төгрөгөөр буюу 3.99 хувиар тасарсан байна.

Бусад асуудал

Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Б/23 дугаар захирамжаар тус сумын Засаг даргыг томилсон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,744,381.90	4,711,542.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,560,324.10	3,556,390.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	176,931.00	262,867.60
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	957,566.70	805,583.70
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	49,560.00	86,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		11,886,160.70	23,820,704.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	11,886,160.70	23,820,704.70
39200	Биет хөрөнгө		11,837,457.40	23,493,593.80
39300	Биет бус хөрөнгө	13	48,703.30	327,111.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		14,630,542.60	28,532,246.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		375,303.20	1,166,262.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	375,303.20	1,166,262.00
41300	Өглөг	17а, 17б	375,303.20	1,087,009.10
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	-	79,252.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		14,255,239.40	27,365,984.80
51	Засгийн газрын хувь оролцоо		14,255,239.40	27,365,984.80
51100	Засгийн газрын оруулсан капитал		715,438.10	715,438.10
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		4,809,936.40	4,809,936.40
51200	Хуримтлагдсан үр дүн		7,530,534.50	20,641,280.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,199,330.30	1,199,330.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		14,630,542.60	28,532,246.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		14,048,146.10	28,536,164.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,273,809.60	1,719,352.30
110	Орлогын албан татвар		1,022,412.40	1,418,743.50
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,022,412.40	1,418,743.50
113	Хөрөнгийн албан татвар		126,038.50	157,778.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		125,358.60	142,830.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,676,912.60	8,006,322.80
120	Нийтлэг татварын бус орлого		1,676,912.60	8,006,322.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		11,097,423.90	18,810,489.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	8,313,953.30	13,126,121.40

21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,313,953.30	13,126,121.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,253,615.30	12,920,412.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,044,340.10	1,575,513.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		128,352.40	190,818.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		159,439.40	243,464.30
2104	Хангамж, бараа материалын зардал		3,106,166.40	6,162,296.20
2105	Нормативт зардал		3,534.00	4,297.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		385,957.60	578,096.10
2107	Томилолт, зочны зардал		4,004.70	4,914.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,202,267.30	1,694,756.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,219,553.40	2,466,254.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		60,338.00	205,708.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		5,734,192.80	15,410,042.70
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,342,675.30	4,261,177.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		2,391,517.50	11,148,865.60

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		21,913,369.40	21,779,222.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,273,809.60	1,482,353.00
110	Орлогын албан татвар		1,022,152.40	1,181,169.20
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,022,152.40	1,181,169.20
113	Хөрөнгийн албан татвар		126,038.50	157,778.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		125,618.60	143,405.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		8,148.80	24,902.20
1181	Газрын төлбөр		112,407.10	116,273.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		5,062.70	2,229.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		983,290.00	1,486,380.60
120	Нийтлэг татварын бус орлого		983,290.00	1,486,380.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		19,656,269.80	18,810,489.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		12,271,831.60	6,183,060.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		12,271,831.60	6,183,060.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,668,029.60	5,978,111.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,247,091.60	1,931,397.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		191,483.10	303,191.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		221,787.20	866,457.80
2104	Хангамж, бараа материалын зардал		256,076.60	385,246.90
2105	Нормативт зардал		9,940.00	25,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		434,291.60	675,053.80
2107	Томилолт, зочны зардал		4,004.70	4,914.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		749,282.10	1,623,420.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		554,072.70	162,527.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,603,802.00	204,949.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		9,641,537.80	15,596,162.50
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		36.70	178.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		8,484,196.40	13,499,535.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		8,484,196.40	13,499,535.80
2200	Дотоод эх үүсвэрээр		8,484,196.40	13,499,535.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(8,484,159.70)	(13,499,357.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		(113,400.00)	(100,738.20)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		113,400.00	100,738.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		1,043,978.10	1,996,066.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		516,346.00	1,560,324.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,560,324.10	3,556,390.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,226,474.90	-	11,226,474.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,226,474.90	-	11,226,474.90
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	637,247.00	-	637,247.00
9	Тайлант үеийн үр дүн	2,391,517.50	-	2,391,517.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,255,239.40	-	14,255,239.40
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,255,239.40	-	14,255,239.40

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,961,879.80	-	1,961,879.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,217,119.20	-	16,217,119.20
19	Тайлант үеийн үр дүн	11,148,865.60	-	11,148,865.60
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	27,365,984.80	-	27,365,984.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,835,386.60	18,214,630.46	3,620,756.14	83.42%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,238,436.20	4,647,657.36	590,778.84	88.72%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,035,504.50	4,445,623.16	589,881.34	88.29%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,578,816.80	1,543,785.34	35,031.46	97.78%
210101	Үндсэн цалин	691,916.80	620,835.91	71,080.89	89.73%
210102	Нэмэгдэл	808,897.00	747,039.70	61,857.30	92.35%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,203.00	34,882.14	14,320.86	70.89%
210104	Урамшуулал	-	131,395.73	(131,395.73)	0.00%
210105	Гэрээт ажлын хөлс	28,800.00	9,631.85	19,168.15	33.44%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	199,318.50	186,960.07	12,358.43	93.80%
210201	Тэтгэврийн даатгал	136,333.50	124,678.50	11,655.00	91.45%
210202	Тэтгэмжийн даатгал	15,746.40	15,706.97	39.43	99.75%
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,983.50	11,495.50	488.00	95.93%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,762.80	3,733.72	29.08	99.23%
210205	Эрүүл мэндийн даатгал	31,492.30	31,345.38	146.92	99.53%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	830,154.00	811,198.83	18,955.17	97.72%
210301	Гэрэл, цахилгаан	89,470.40	77,561.80	11,908.60	86.69%
210302	Түлш, халаалт	712,728.90	712,719.74	9.16	100.00%
210303	Цэвэр, бохир ус	27,954.70	20,917.29	7,037.41	74.83%
2104	Хангамж, бараа материалын зардал	192,249.70	192,218.76	30.94	99.98%
210401	Бичиг хэрэг	31,045.50	31,045.50	-	100.00%
210402	Тээвэр, шатахуун	81,022.00	81,020.00	2.00	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,466.40	8,437.46	28.94	99.66%
210404	Ном, хэвлэл	2,500.00	2,500.00	-	100.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,908.00	21,908.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,307.80	47,307.80	-	100.00%
2105	Нормативт зардал	25,900.00	25,900.00	-	100.00%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	25,900.00	25,900.00	-	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	681,774.50	681,438.00	336.51	99.95%
210601	Багаж, техник, хэрэгсэл	85,969.30	85,969.30	0.01	100.00%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,500.00	15,500.00	-	100.00%

210604	Урсгал засвар	580,305.20	579,968.70	336.50	99.94%
2107	Томилолт, зочны зардал	5,614.70	4,914.70	700.00	87.53%
210702	Дотоод албан томилолт	5,614.70	4,914.70	700.00	87.53%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,372,731.00	850,265.30	522,465.70	61.94%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,288,087.00	766,840.62	521,246.38	59.53%
210803	Даатгалын үйлчилгээ	2,258.20	2,235.49	22.71	98.99%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,500.00	1,463.04	36.96	97.54%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	584.50	584.50	-	100.00%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	58,080.00	58,080.00	-	100.00%
210807	Газрын төлбөр	1,000.00	790.35	209.65	79.03%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,221.30	20,271.30	950.00	95.52%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,945.30	148,942.18	3.12	100.00%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,195.30	136,192.18	3.12	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,750.00	12,750.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	202,931.70	202,034.20	897.50	99.56%
2132	Бусад урсгал шилжүүлэг	202,931.70	202,034.20	897.50	99.56%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	90,944.50	90,238.44	706.06	99.22%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,355.20	78,163.76	191.44	99.76%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,822.00	9,822.00	-	100.00%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,810.00	23,810.00	-	100.00%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,423,158.90	13,466,234.90	2,956,924.00	82.00%
220001	Барилга байгууламж	10,776,712.30	9,926,470.00	850,242.30	92.11%
222001	Тоног төхөөрөмж	1,637,165.40	973,667.35	663,498.06	59.47%
223001	Бусад хөрөнгө	4,009,281.20	2,566,097.55	1,443,183.65	64.00%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	173,791.50	100,738.20	73,053.30	57.96%
230001	Эргэж төлөгдөх зээл	173,791.50	100,738.20	73,053.30	57.96%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,835,386.60	19,048,288.48	2,787,098.12	87.24%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,358,244.90	10,338,777.40	19,467.50	99.81%
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	10,358,244.90	10,338,777.40	19,467.50	99.81%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,896,831.60	8,649,067.03	1,247,764.57	87.39%
320001	Орон нутгийн төсвөөс	9,896,831.60	8,649,067.03	1,247,764.57	87.39%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,580,310.10	60,444.05	1,519,866.05	3.82%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,270.00	60,444.05	(12,174.05)	125.22%

350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,532,040.10	-	1,532,040.10	0.00%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	436,936.13	(436,936.13)	0.00%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,270,594.15	(1,270,594.15)	0.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,804.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,804.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	215,886.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,169.80
210101	Үндсэн цалин	24,818.07
210102	Нэмэгдэл	2,373.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,858.84
210201	Тэтгэврийн даатгал	2,624.03
210202	Тэтгэмжийн даатгал	308.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	154.40
210204	Ажилгүйдлийн даатгал	154.40
210205	Эрүүл мэндийн даатгал	617.20
2104	Хангамж, бараа материалын зардал	89,782.81
210401	Бичиг хэрэг	3,255.00
210402	Тээвэр, шатахуун	85,084.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,443.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,585.10
210604	Урсгал засвар	13,585.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,489.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,489.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,918.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,915.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,915.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3.64
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3.64
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,804.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218,804.73
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	216,812.73
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,992.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж “Оновчтой бодлогоор үлгэрлэн манлайлагч байгууллага байна” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага юм.

Алсын хараа: Дэд бүтэц, ногоон хөгжлөөрөө тэргүүлэгч Монгол Улсын жишиг сум болно.

Үнэт зүйл: Мэдлэг ур чадвар, Ёс зүй, Туршлага, Бүтээлч үр дүн, Хариуцлага

Чанарын бодлого: Оновчтой төлөвлөлт, зөв бодлого шийдвэрээр иргэдийг ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, чадварлаг албан хаагчид, дэвшилтэт цахим технологиор мэдээллийн ил тод байдлыг ханган, хуулийн хүрээнд нийтийн эрх ашгийг дээдэлж үр дүнтэй гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага байна.

Байгаль орчны бодлого: Байгаль орчны талаарх хууль эрх зүйн шаардлагыг биелүүлэн сумын хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо байгальд ээлтэй байх шаардлагыг нэн тэргүүнд тавин, өөрсдийн дотоод үйл ажиллагаанд ашиглагдах цаас болон эрчим хүчний хэрэглээг боломжит бага түвшинд байлгаж, хог хаягдлыг оновчтой шийдлээр дахин ашиглалтад оруулж, нийт ажилтан албан хаагчдад “Эко” хандлагыг төлөвшүүлсэн “Ногоон сум”-ыг хөгжүүлэхэд түүчээлэгч байгууллага байна.

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн”, 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн” гэж заасан бөгөөд нийт 23 бүрэн эрхийг тусгасан байна.

Орхон аймгийн Жаргалант сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилт нь:

- Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг нэмэгдүүлэн, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Нийтийн биеийн тамирыг олон нийтийн дунд өрнүүлэх чиглэлээр гарсан санал санаачилгыг дэмжин идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэх иргэд, уралдаан тэмцээнд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.
- Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд нийгмийн хамгааллын үйлчилгээ бүрэн үзүүлж, хүүхдийн эрх хөгжил, хамгааллыг сайжруулж, хүүхэд гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- Зорилтот бүлэгт чиглэсэн ажлын байрыг бий болгон, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангаж өрх, иргэнийг орлоготой болгосноор амьжиргаагаа дээшлүүлэх боломж олгоно.
- Нийгмийн халамжийн үйлчилгээг дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх иргэдэд хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.
- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ.

- Соёл урлагийн байгууллагын материаллаг бааз, хөрөнгө оруулалт, иргэдэд үзүүлэх, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг сайжруулна.
- Сумын иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан санал, санаачилгыг дэмжих.
- Сумын төвийн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг сайжруулан иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, сумын соёлыг төлөвшүүлнэ.
- Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.
- Сумын төрийн албаны хүний нөөцийн чадавхыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.
- Сумын гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах төлөвлөлтийг сайжруулж, бэлэн байдлын нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайланд онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 8, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3, Хөдөлмөрийн тухай хуульд 2, Төрийн албаны тухай хуульд 5 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор цалингийн сүлжээ өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл болон шилэн данс, төрийн хэмнэлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Жаргалант сумын Засаг даргын дэргэд дотоод аудитор ажилладаггүй, Төсвийн тухай хуулиар ТЕЗ нь дотоод аудитын алба байгуулж, дотоод аудитор ажиллуулах зохицуулалттай тул Орхон аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас нэгтгэлд хамаарах байгууллагуудад хяналт, шалгалт хэрэгжүүлдэг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Жаргалант сум нь Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар баталсан “Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байгаа бөгөөд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,901,704.2 мянган төгрөгөөр буюу 95.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,560,324.15	3,556,390.80	1,996,066.65
Авлага	176,931.04	262,867.59	85,936.55
Бараа материал	957,566.67	805,583.70	(151,982.97)
Нөөцийн бараа	49,560.00	86,700.00	37,140.00
Үндсэн хөрөнгө	11,886,160.72	23,820,704.72	11,934,544.00
Нийт хөрөнгө	14,630,542.58	28,532,246.81	13,901,704.23
Өр төлбөр	375,303.23	1,166,262.04	790,958.81
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,255,239.35	27,365,984.77	13,110,745.42
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,630,542.58	28,532,246.81	13,901,704.23

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оноос мөнгөн хөрөнгө 1,996,066.6 мянган төгрөгөөр, авлага 85,936.5 мянган төгрөгөөр, нөөцийн бараа 37,140.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 11,934,544.0 мянган төгрөгөөр тус тус өссөн, бараа материал 151,982.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,556,390.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,996,066.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	1,560,324.15	3,556,390.80	1,996,066.65
Төгрөг	1,560,324.15	3,556,390.80	1,996,066.65
Төрийн сангийн харилцах	1,545,825.78	3,554,514.00	2,008,688.22
Арилжааны банк дахь харилцах	14,498.37	1,876.80	(12,621.57)
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	1,560,324.15	3,556,390.80	1,996,066.65

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн данс өссөн нь ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс он дамжсан зарцуулаагүй 978,021.8 мянган төгрөгийн үлдэгдэл болон чанарын баталгааны 616,521.5 мянган төгрөгийн өглөгөөс шалтгаалсан байна.

Арилжааны банкин дахь үлдэгдэл нь “Жаргалант ус, дулаан түгээх станц” орон нутгийн өмчит хувьцаат компанийн мөнгөн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 99.9 хувийг төрийн сангийн харилцах, 0.1 хувийг арилжааны банкны харилцах эзэлж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 261,867.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 84,936.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Дансны авлага /ТӨҮГ/	24,180.55	26,509.86	2,329.31
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	13,483.59	42,227.48	28,743.89
Байгууллагаас авах авлага	139,266.90	193,130.25	53,863.35
Дүн	176,931.04	261,867.59	84,936.55

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын данстай холбоотой 3.6 мянган төгрөгийн устгах бичилт хийсэн байна.

Авлагын дансны өсөлт нь Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд нэмж олгосон зээлийн авлага болон “Жаргалант ус, дулаан түгээх сүлжээ” ОНӨХК-ийн авлагын өсөлттэй холбоотой байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 805,583.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,982.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Түүхий эд материал	528,014.17	444,191.20	(83,822.97)
Тусгай зориулалттай материал	528,014.17	444,191.20	(83,822.97)
Хангамжийн материал	5,922.00	5,922.00	-
Бусад хангамжийн материал	5,922.00	5,922.00	-
Мал амьтад	423,630.50	355,470.50	(68,160.00)
Дүн	957,566.67	805,583.70	(151,982.97)

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын дансны бууралт нь Жаргалант сумын ЗДТГ нь тайлант онд цаашид ашиглах боломжгүй 270,551.7 мянган төгрөгийн 88 нэр төрлийн 1758 ширхэг тусгай зориулалтын бараа материал, 68,160.0 мянган төгрөгийн насжилт болон үржлийн хээлтүүлгийн чанарын шаардлага хангахгүй махны чиглэлийн 8 толгой хээлтүүлэгч бухыг данснаас хассанаас шалтгаалсан байна.

3.4.4 Нөөцийн бараа

Нөөцийн бараа данс нь өвөлжилтийн бэлэн байдлыг хангах хүрээнд бэлтгэсэн 86,700.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн нөөц байгаа нь өмнөх оноос 74.9 хувиар өссөн байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 23,820,704.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,934,544.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Биет хөрөнгө	11,837,457.38	23,493,593.77	11,656,136.39
Барилга, байгууламж, орон сууц	8,170,421.41	15,654,498.03	7,484,076.61
Авто-тээврийн хэрэгсэл	729,204.38	1,229,622.98	500,418.60
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,163,887.50	1,243,204.00	79,316.50
Тавилга, аж ахуйн эд хогшил	380,590.60	405,828.84	25,238.25
Бусад үндсэн хөрөнгө	1,383,353.49	4,702,108.96	3,318,755.47
Дуусаагүй барилга, байгууламж	10,000.00	10,000.00	-
Зам гүүрний байгууламж	-	248,330.96	248,330.96
Биет бус хөрөнгө	48,703.34	327,110.95	278,407.61
Программ хангамж	3,059.34	4,319.74	1,260.40
Бусад биет бус хөрөнгө	45,644.00	322,791.21	277,147.21
Дүн	11,886,160.72	23,820,704.72	11,934,544.00

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант оны элэгдлийн зардлаар буурч тайланд онд ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Жаргалант сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн данс тайлант онд 11,452,883.8 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС, хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд 8,909,686.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан, ОНХО-н болон урсгал зардлаас 3,971,157.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,087,009.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 698,879.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Ажилчидтай холбогдсон өглөг	-	12,826.42	12,826.42
Байгууллагад төлөх өглөг	347,335.40	1,036,440.86	689,105.46
Хувь хүмүүст төлөх өглөг	21,900.00	2,281.30	(19,618.70)
Татварын өглөг /ТӨҮГ/	5,952.45	35,182.05	29,229.60
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	115.39	278.47	163.08
Дүн	375,303.23	1,087,009.09	698,879.44

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Өр төлбөр данс нь ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын баталгааны 5 хувийн өглөг болон ОНӨХК-ийн өглөгийн өсөлттэй холбоотойгоор нэмэгджээ.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 27,365,984.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,110,745.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	715,438.05	715,438.05	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,809,936.44	4,809,936.44	-
Хуримтлагдсан үр дүн	7,530,534.53	20,641,279.95	13,110,745.42
Өмнөх үеийн үр дүн	5,139,017.02	9,492,414.34	4,353,397.32
Тайлант үеийн үр дүн	2,391,517.51	11,148,865.61	8,757,348.10
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,199,330.32	1,199,330.32	-
Дүн	14,255,239.34	27,365,984.76	13,110,745.42

Эх сурвалж: Жаргалант сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо данс нь тайлант оны үр дүнгээр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 01 дүгээр тогтоолоор Жаргалант сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 21,835,386.6 мянган төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсөв 1,643,924.7 мянган төгрөг, төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 8,252,906.9 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 10,358,244.9 мянган төгрөг, урьд оны шилжих үлдэгдэл 1,399,418.6 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогоор 7,100.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотгон¹ 701,537.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Жаргалант сумын төсөвт төвлөрөх 2024 оны татварын орлогыг 1,543,924.7 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,482,353.0 мянган төгрөг төвлөрч, 61,571.7 мянган төгрөгөөр буюу 3.99 хувиар тасарсан байна.

Хүснэгт 8. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Сумын төсвийн орлого	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Урсгал орлого	1,651,024.70	1,591,871.82	(59,152.88)
1.1	Татварын орлого	1,543,924.70	1,482,352.99	(61,571.71)
1.1.1	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	1,030,604.50	906,496.40	(124,108.10)
1.1.3	Үйл ажиллагааны орлого	13,000.00	11,136.58	(1,863.42)
1.1.4	Хөрөнгийн орлого	80,000.00	72,695.08	(7,304.92)
1.1.5	Хөрөнгө борлуулсны орлого	18,000.00	39,696.71	21,696.71
1.1.6	Шууд бус орлого	108,329.10	151,144.44	42,815.34
1.1.7	Бусад орлого /бичил үйл ажиллагааны орлого/	250.00	575.00	325.00
1.1.8	Малын хөлийн албан татвар	37,352.60	38,099.86	747.26
1.1.9	Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	122,853.50	118,808.84	(4,044.66)
1.1.10	Бууны албан татвар	800.00	870.00	70.00
1.1.11	Байгалийн ургамлын НАТөлбөр	1,200.00	-	(1,200.00)
1.1.12	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.00	3,516.15	1,516.15
1.1.13	Газрын төлбөр	115,000.00	116,273.01	1,273.01
1.1.14	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,500.00	3,210.00	(290.00)
1.1.15	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	6,000.00	17,601.00	11,601.00
1.1.16	Ус, рашаан ашигласны төлбөр	3,000.00	577.38	(2,422.62)
1.1.17	Ойн нөөц ашигласны төлбөр	2,035.00	1,652.54	(382.46)
1.2	Татварын бус орлого	107,100.00	109,518.83	2,418.83
1.2.1	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7,100.00	7,860.29	760.29
1.2.2	Хүү, торгуулийн орлого	100,000.00	101,658.54	1,658.54

Татварын бус орлого 2,418.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар давж биелсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

¹ Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Ээлжит бус IV хуралдааны 01 дүгээр тогтоол

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 218,804.7 мянган төгрөгийн орлого авч, бараа үйлчилгээний урсгал зардалд 215,886.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 2,915.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Жаргалант сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн 2024 оны үнэлгээг дараах байдлаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэсэн байна. Үүнд:

- Эрүүл Жаргалантчууд – 96.6 хувь
- Боловсрол хөтөлбөр – 90.0 хувь
- Малжуулах хөтөлбөр - 100.0 хувь
- Жаргалантын ногоочид хөтөлбөр – 100.0 хувь

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхажва нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/137 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 28,532,246.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 427,983.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 299,588.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй суудлын авто машин болон бусад тээврийн хэрэгслийн улсын дугаарыг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 8.2-д заасан ТЕЗ-ийн хяналтыг Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг байна. Жаргалант сумын Засаг даргын төсвийн багцад хамаарах байгууллагуудын Шилэн дансны хууль, тогтоомжийн биелэлтэд 2024 онд нийт 4 удаа буюу улирал бүр төлөвлөгөөт хяналт хийж, байгууллага тус бүрд бодит байдал, илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудлыг тусгасан товч тайлан зөвлөмжийг хүргүүлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Жаргалант сумын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 56,978.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 50,015.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, 6,963.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Албан шаардлага,

зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 01/375 дүгээр албан тоотгоор ирүүлсэн байна.

Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	50,015.0	2	50,015.0	100.0
Албан шаардлага	1	6,963.8	1	6,963.8	100.0
Нийт дүн	3	56,978.8	3	56,978.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал дансыг авч үзэж болох юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 568.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 568.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд нийт 9 байгууллага нэгтгэгджээ. Боловсрол, соёл, эрүүл мэндийн 4 байгууллага нь босоо тогтолцоотой тул орон нутгаас авсан санхүүжилтийн хүрээнд орлого, зардлаа тайлагнасан байна.

Хүснэгт 10. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр (тоогоор)				Нийт дүн
		ТАБ		ХАК		
		Дүгнэлт	Түүвэр	Дүгнэлт	Түүвэр	
1	Төсвийн шууд захирагч	2	2	0	0	4
2	ОНӨХК	1	0	0	0	1
3	ТТЗ	1	0	0	0	1
	Дүн	4	2	0	0	6

Дүгнэлт гаргасан 3 байгууллагад өөрчлөлтгүй санал дүгнэлт өгсөн ба “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 05 дугаартай албан бичгийн хамт ирүүлсэн боловч санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарласан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчил, тэдгээрийн шийдвэрлэлтийг энэ тайлангийн 7-д харуулав.

5.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Жаргалант сумын ИТХ-д олгох санхүүжилтийг илүү олгосон зөрчилд 568.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК-ний албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жаргалант сумын татварын орлого нийт дүнгээрээ 392,275.6 мянган төгрөгөөр тасарсан байхад 61,571.7 мянган төгрөгөөр тасарснаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 23.8-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.8.17-д "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын татварын байцаагч дансны хуулга болон бусад анхан шатны баримтад үндэслэн мэдээ тайлангаа үнэн зөвөөр тайлагнаж, татвар бүрдүүлэлтэд хяналт тавин ажиллах.

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жаргалант сумын татварын орлого нийт дүнгээрээ 392,275.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 23.8-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.8.17-д "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын төсөвт төвлөрүүлэх төсвийн орлого бүрдүүлэлтэд хяналт хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жаргалант сумын ИТХ-д олгох санхүүжилтийг батлагдсан төсвөөс 568,000 төгрөгөөр илүү олгосон байна.	1	568.0			1	568.0						
Жаргалант сумын татварын орлого нийт дүнгээрээ 392,275.6 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	-					1	-				
Жаргалант сумын татварын орлого нийт дүнгээрээ 392,275.6 мянган төгрөгөөр тасарсан байхад 61,571.7 мянган төгрөгөөр тасарснаар тайлагнасан байна.	1	-					1	-				
Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг "Жаргалант ус дулаан түгээх станц" ОНӨХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 05 дугаартай албан бичгийн хамт ирүүлсэн боловч санхүүгийн анхан шатны баримт, материалыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл ирүүлээгүй нь тайланд дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах цаг хугацааг хязгаарлаж байна.	1	-							1	1		
Дүн	4	568.0			1	568.0	2	-	1	1		

7. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Нэгтгэлд хамрагдсан нийт байгууллагуудын аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Дүгнэлт гаргах	Түүвэрт	Гаргасан дүгнэлт				Алдаа зөрчлийн ангилал						Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
				Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан	Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт			
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	1		1				2	-	2	568.0			4	568.0
2	Жаргалант сумын ЗДТГ	1		1				2	1,625.0	4	58,732.9			6	60,357.9
3	Жаргалант сумын ИТХурал	1		1				3	4,020.1			2	3,206.1	5	7,226.2
4	Жаргалант сумын ОНХСан		1					2	262,014.2					2	262,014.2
5	Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1		1				1	2,487.0					1	2,487.0
6	Жаргалант ус, дулаан түгээх станц ОНӨХК	1					1							0	0.0
Бүгд дүн		5	1	4			1	10	270,146.3	6	59,300.9	2	3,206.1	18	332,653.3